**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 06 өдөр    Дугаар A/189    Мандалговь

Нэмэлт гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дугаар хавсралтад үнийн өсөлтийн зөрүү батлагдсан Дэвжих эрдэнэ ХХК-ийн гүйцэтгэсэн “Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/” ажлын 2023 онд батлагдсан үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт болох 84,863,217 (наян дөрвөн сая найман зуун жаран гурван мянга хоёр зуун арван долоо) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

2. Үнийн өсөлтийн нэмэлт санхүүжилт олгоход шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн ажиллахыг “Дэвжих эрдэнэ” ХХК-ийн захирал (Д.Баянбаатар)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Санхүү төрийн сангийн хэлтсийн ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА    Ц.МӨНХБАТ

48 3100 20